

“ДҮЙРА”-НЫ ТОВЧ ОЙЛЛОГО

(дүйра-ны үүсэл хөгжил, дүйра зохиолууд)

Р.Алтансүх – ШУА. ФСЭЗХ-ийн ЭША. магистр

Буддын шалгадаг ухааны нэгэн нэн чухал бүрэлдэхүүн нь “дүйра” (bsdus grwa) юм. Дүйра-г XII зууны үед төвдүүд бий болгожээ. Тухайн үеийн төвдүүдэд орчуулгын ном зохиолуудаар дамжуулан буддын мэдлэг ухаанд суралцах нь бэрхшээлтэй байсан тул тэд өөрсдийн хэлний онцлогт тохируулсан сургалт, судалгааны хялбар арга барил болох *хураангуй* (bsdus pa)-г боловсруулсан байна¹¹⁰. Энэ нь яваандаа уламжлал болон тогтож буддын философийн салбар бүрээр *хураангуй* зохиогдох болжээ. Төвдийн сэтгэгч Чава Чойжисэнгэ (1109-1169) шалгадаг ухааны үндсэн шастаруудын утгыг хураангуйлан найруулж “Шалгадгийн хураангуй, сэтгэлийн харанхуйг арилгагч”¹¹¹ нэртэй зохиол туурвисан нь *шалгадгийн хураангуй* (tshad bsdus)-н эхлэл болсон гэж үздэг [Лүнрэг-нима: 6a]. *Шалгадгийн хураангуй* нь яваандаа эхлэн суралцагсдад зориулсан ерөнхий удиртгал болох *дүйжор*¹¹² буюу *дүйра*, танин мэдэхүйн онолын удиртгал болох *лориг* (blo rig), учир зүйн удиртгал болох *дагриг* (rtags rig) гэсэн гурван үндсэн хэсэгт хуваагдаж тус бүрээр нь олон тооны ном зохиол бичигджээ. *Дүйра* буюу *хураангуй хүрээ* гэдэг нь *хураангуйд суралцах сургуулийн хүрээ*¹¹³, *олон зүйл зохист ухааныг нэгэн зүгт хураангуйлсан хүрээ*¹¹⁴ гэсэн утгуудыг илэрхийлдэг. Эх сурвалжуудад өгүүлсэнээр бол “шалгадаг ухааны шастаруудын утгыг ойлгохуйяа бэрх байсан тул тэдгээрийн утгын шимийг хураангуйлан найруулсан нь *хураангуй найруулга* буюу *хураангуй хүрээ*” [Лондол лам: 26, Лүнриг-нима: 5a-6a, Нима-одсэр: 1756, Онцар-гаадон: 37a] ажээ.

Шалгадаг ухаан ба дүйра

Эртний энэтхэгийн сэтгэгчид логик, танин мэдэхүйн онолын сэдвүүдэд ихээхэн анхаарал хандуулдаг байжээ. Ялангуяа буддын сэтгэгчид шалгадаг ухааныг бие даасан мэдлэг ухаан (rig gnas) болгон хөгжүүлэхдээ шалгадаг ухаан гэдэг нэрийн дор логик, танин мэдэхүйн онолын асуудлуудыг судлан боловсруулсаар ирсэн байна. Эх зохиолуудад өгүүлснээр бол Будда Шакъяамүни бээр шавь нартаа айлдсан айлдвар сургаалуудын цаад учир зүй нь буддын шалгадаг ухааны үндэс болсон гэдэг [Дигнага: 143, Дэвдүн: 8-9, Багсам-жонсан: 271]. Хожим тэдгээр сургаалд үндэслэн Дхаммадата¹¹⁵ архат “Өгүүлэхүйн зул” (sMras pa'i sgron me) нэртэй шалгадаг ухааны шастар зохиосон тухай мэдээ бий [Ча-рий: 33]. Хэдийгээр Асанга (IV зуун), Васубанду (IV зуун) нар шалгадаг ухааныг хөгжүүлж байсан боловч түүнийг системчлэн, мэдлэг ухааны цогц байдлаар анхлан илэрхийлсэн хүн нь Дигнага (V зуун) ажээ. Тиймээс Дигнагийг буддын

¹¹⁰ Лоцава Ог Лодоншийрав (1059-1109) *dBu ma'i bsdus pa* (Мадхьямакийн хураангуй)-г зохиосноор *bsdus pa* ёсон бий болсон гэж үздэг.

¹¹¹ *tshad bsdus yid kyi mun sel*

¹¹² *bsdus sbyor* - хураангуй найруулга

¹¹³ *bsdus pa slob pa'i sde tshan gyi grwa*

¹¹⁴ *rigs pa'i nam grangs du ma phyogs gcig tu bsdus pa'i grwa*

¹¹⁵ төвд. chos skyob - Вайбхашика тогтсон тааллын анхны багш нарын нэг бөгөөд буддын бага хөлгөний шарвакийн мөрөөр замнаж нисванисаа тэвчсэнээр *dgra bcom pa* буюу *архат* болсон гэдэг. Түүнийг Будда-гаас шалгадаг ухааныг залгамжилсан хэмээн *Хөх дэвтэрт* тэмдэглэжээ [Дэвтэр онбо: 421].

шалгадаг ухааныг үндэслэгч гэж тооцдог. Тэрээр “Шалгадаг хотлоос түүсэн”¹¹⁶ хэмээх бүтээлдээ саудрантика болон йогачара философийн онолын үндэслэлүүдэд тулгуурлан шалгадаг ухааны гол гол дүрэм, зарчмуудыг анхлан томъёолж, түүний бүтэц, зохион байгуулалтыг өнөөгийн бидэнд уламжлагдан ирсэн яг энэ хэлбэрээр нь чандлан тогтоосон байдаг. Шалгадаг ухааны уламжлалд энэ зохиолыг “Шалгадаг судар”¹¹⁷ хэмээн нэрлэж заншжээ. Дигнагийг залгамжлан гарч ирсэн томоохон шалгадаг ухаантан болох Дхармакирти (VII зуун) “Праманасутра”-г тайлбарлаж “Шалгадгийн тийн тайлбар”¹¹⁸ хэмээх зохиол туурвисан нь ихэд алдартай юм. Төвд, монголын буддын уламжлалд энэ зохиол нь шалгадаг ухаанд суралцах үндсэн шүн¹¹⁹ болон хэрэглэгдэж иржээ. Дигнага, Дхармакирти нарыг залгамжлан Шакъябудхи, Девендрабудхи, Дхармоттара зэрэг олон олон сэтгэгчид буддын шалгадаг ухааныг уламжлан хөгжүүлсэн бөгөөд төвд хэл дээр л гэхэд Энэтхэгийн мэргэдийн туурвисан шалгадаг ухааны 60 гаруй шастар орчуулагдсан [Бүдөн чойнжун: 249-251, HBLT: 11-24] нь 21 боть болон эмхлэгдэж, төвд данжуурын шалгадаг ухааны аймгийг бүрдүүлж байдаг¹²⁰.

Мөн Нагаржуна төв үзэлд тулгуурласан нэгэн зүйл шалгадаг ухааныг үндсэлсэн бөгөөд түүнийг Буддхапалита, Чандракирти, Лувсандагва, Агваанзондуй, Агваанбалдан, Зава Дамдин зэрэг үе үеийн төв үзлийн онолчид уламжлан хөгжүүлсэн ажээ¹²¹.

Төвдөд дэлгэрсэн буддын шалгадаг ухааны түүх нь төвдөд дэлгэрсэн бурхны шашны түүхийн үндсэн үе шатуудтай холбоотой юм. Төвдийн бурхны шашны түүхийг эх сурвалжуудад хоёр үе болгон авч үзсэн байдаг. Эхний дэлгэрэлт (V зууны дунд үеэс X зууны эхэн хүртэл) -ийн үед Гава Балзэг, Жагро Лүи-жалцан, Шан Иший-Дэ зэрэг лозава нар Дигнагийн зохиол бүтээлүүдийг орчуулж байсан нь VII зууны үед хамрагдах боловч энэ үед шалгадаг ухаан төдийлөн дэлгэрч амжаагүй ажээ. Харин төвдийн бурханы шашны хожуу дэлгэрэлт (XI зуун)-ийн эхэн үеэс Ма Гээвий-Лодой тэргүүтэн дуун хөрвүүлэгчид шалгадаг ухааны ном зохиолуудыг орчуулах, өмнөх орчуулгуудыг хянах ажлыг эхлүүлсэн бөгөөд энэ үеийн шалгадаг ухааныг чойнжун¹²² зохиолуудад “хуучин шалгадаг ухаан” (tshad ma rnying ba) хэмээн тэмдэглэсэн буй. Харин энэтхэгийн их пандида Атиша (982-1054) төвдөд их хөлгөний сургаалыг дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулсан нь буддын шалгадаг ухаан төвд газар ул суурьтай дэлгэрэн хөгжих таатай нөхцөлийг бүрдүүлсэн байна. Улмаар түүний дотны шавь, лозава Ог Лэгвийшийрав (XI зуун) бээр Атишагийн зарлиг захиасаар 1073 онд төвдийн алдарт Санпү хийдийг байгуулж буддын бэлгэ чанарын хөлгөний (mtshan nyid kyi theg pa) сургаалыг дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулсан нь шалгадаг ухааны дэлгэрэлтэнд хүчтэй түлхэц болжээ. Түүний дүү Ог Лодоншийрав (1059-1109) ахынхаа үйлсийг залгамжлан, ингэхдээ голлон шалгадаг ухааныг хөгжүүлэхэд ихээхэн анхаарал тавьсан байдаг. Тэрээр санскрит, хятад зэрэг хэлнээс төвд хэлэнд орчуулагдсан буддын шалгадаг ухааны шастаруудыг ариутган шүүх, шинээр орчуулах, гол шастаруудад тайлбар хийх

¹¹⁶ санс. *Pramanasamuccaya*, төвд. *Tshad ma kun las btus pa*

¹¹⁷ санс. *Pramanasutra*, төвд. *Tshad ma mdo*

¹¹⁸ санс. *Pramanavartika*, төвд. *Tshad ma rnam 'grel*

¹¹⁹ Gzhung – сургалт, судалгааны үндсэн эх сурвалж, хэрэглэгдэхүүнийг ийн нэрлэнэ.

¹²⁰ Эдгээр зохиолуудын монгол орчуулга нь *Монгол данжуурын* дотор бүрэн эхээрээ буй.

¹²¹ Энэ талаар дээрх сэтгэгчдийн зохиол бүтээлүүдээс дэлгэрүүлэн үзэх боломжтой.

¹²² Chos 'byung – буддын шашин, философийн түүхийн ойлбор бичиг

зэрэг ажлуудыг зохион байгуулжээ¹²³. Энэ үеэс “шинэ шалгадаг ухаан” (tshad ma gsar ba)-ы үе эхэлсэн гэж тооцдог ба төвдийн мэргэд шалгадаг ухааны ном зохиол туурвих эхлэл тавигдсан гэж үздэг. Өмнө нь төвдүүд зөвхөн орчуулгын зохиолуудад тулгуурлан сургалт, судалгаа хийдэг байсан бол энэ үеэс эх сурвалжуудад тайлбар бичих, бие даасан болон судалгаа шинжилгээний бүтээлүүд туурвих болсон байна.

Төвдүүд буддын шалгадаг ухааны бүхий л чиглэл, сэдвүүдээр олон тооны зохиол бүтээлүүдийг туурвисан байдаг. Тухайлбал, Ог Лодоншийравын “Шалгадаг тийн магадлахуйн тайлбар”¹²⁴, Жалцав Дармаринчэнгийн “Шалгадаг тийн тайлбарын номлол тонилох мөрийг тодруулагч”¹²⁵ зэрэг томоохон тайлбар бүтээлүүд, Сажан бандид Гунгаажанцангийн “Шалгадаг ухааны сан”¹²⁶, Бүдөн Ринчэндүвийн “Шалгадаг уг, үтга машид тодорхой”¹²⁷ зэрэг бие даасан бүтээлүүд, Хайдүв Гэлэгбалсангийн “Шалгадгийн долоон шастарын чимэг сэтгэлийн мунхагыг арилгагч”¹²⁸, Гэндэндүвийн “Шалгадийн шастар ухааны чимэг”¹²⁹ зэрэг шалгадаг ухааныг онол, арга зүйн хувьд ерөнхийд нь авч үзсэн бүтээлүүдээс гадна *шалгадгийн мөрийн хөтөлбөр*¹³⁰ хэмээх шалгадаг ухаан, бодь мөрийн зэргийн хавсарсан шинжилгээний бүтээлүүд, *шалгадаг ухаанаас гарсан нэрийн зүйл*¹³¹ хэмээх шалгадаг ухааны гол агуулга, нэр томъёоны тайлбар, ном зохиолын тойм сэлтийг багтаасан бүтээлүүд зэрэг өөр өөр тогтсон таалал, дэг сургуулийн мэргэдийн тоолж баршгүй олон бүтээлүүд гарчээ.

Санпү хийдээс Лодойжунай (Долүнба), Лодойжанчүв (Ганба Шэү), Чун Ринчэндагва, Шан Цэбон, Жанчүвдагва (Додлүн Жамарва) зэрэг шалгадаг ухаанд мэргэшсэн олон мэргэд төрөн гарсан ба XII зууны дунд үе гэхэд Санпү хийд нь шалгадаг ухаанд суралцах гол төв болж Төвдийн их зургаан хийдийн нэгд тооцогдох болжээ [Шинса: 461]. Улмаар шалгадаг ухаанд суралцахийг хүссэн олон олон залуус Санпү хийдийг зорих болсноор төвдөд дэлгэрсэн буддын шалгадаг ухааны боловсрол олгох сургалтын систем нь гэрийн багшийн сургалтаас сүм хийдийн сургалтын системд шилжих үйл явц идэвхтэй явагдаж, ингэснээр шалгадаг ухаанд суралцуулах шаталсан сургалтын тогтолцоо, тэдгээрт тохирох сургалтын шинэ арга барилыг бий болгох шаардлага тулгарчээ.

Долүнба, Додлүн Жамарва нарын шавь, Санпү хийдийн зургадугаар ширээт лам Чава Чойжи-Сэнгэ (1109-1169) шалгадаг ухааны сэдвүүдийг ангилан эмхтгэж, суралцагсдын түвшинд нь тохируулан шатлан сургах хөтөлбөр, мөн шалгадаг ухааны асуудлуудыг хэлэлцэх хэлцээ, маргааны аргыг бий болгосон нь дүйра-ны эхлэл болсон гэж үздэг [Хайви-гаадон: 729, Багсам-жонсан: 390, Лондол лам: 26].

Чава Чойжисэнгэ *шалгадгийн хураангуй* зохиол бичсэн тухай мэдээ бий боловч тэр нь одоогоор олдоогүй юм [HBLT: 31]. Тиймээс Чава анх дүйра-ны хэдэн сэдвийг

¹²³ Ог Лодоншийрав болон түүнийг залгамжилсан олон тооны томоохон орчуулагчдаас зөвхөн шалгадаг ухаанаар тогтохгүй философийн асар том уламжлал үүссэн буй [Хөх дэвтэр: 399-415, Blue Annals. Book 6].

¹²⁴ *Tshad ma nam nges kyi tika*

¹²⁵ *Tshad ma nam 'grel kyi nam bshad thar lam gsal byed*

¹²⁶ *Tshad ma rigs pa'i gter*

¹²⁷ *Tshad ma tshig don rab gsal*

¹²⁸ *Tshad ma'i bstan bcos sde bdun gyi rgyan yid kyi mun sel*

¹²⁹ *Tshad ma'i bstan bcos rigs pa'i rgyan*

¹³⁰ *Tsham ma'i lam 'khrid*

¹³¹ *Tshad ma rig pa las byung ba'i ming gi nam grangs*

боловсруулсан нь тодорхойгүй бөгөөд Лондол лам (1719-1794/5)-ын мэдээлж байгаагаар 18 байсан бололтой.

- (1) *kha dog dkar dmar* (өнгө: цагаан, улаан)
- (2) *rdzas chos ldog chos* (эдийн ном, няцлагын ном)
- (3) *'gal dang mi 'gal* (харш, харш бус)
- (4) *spyi dang bye brag* (ер, өвөрмөц)
- (5) *'brel dang ma 'brel* (барилдлага, барилдлага бус)
- (6) *tha dad tha dad min* (ангид, ангид бус)
- (7) *rjes su 'gro ldog* (даган одох, няцах)
- (8) *rgyu dang 'bras bu* (шалтгаан, үр)
- (9) *snga btsan bar btsan phyi btsan* (өмнөх хүчтэй, завсарынх хүчтэй, хойдох хүчтэй)
- (10) *mtshan mtshon* (бэлгэ чанар, бэлгэдэгдэхүүн)
- (11) *rtags mang gsal mang* (учир олон, тодорхой олон)
- (12) *dgag pa phar tshur* (янагш хаах, чинагш хаах)
- (13) *dngos 'gal rgyud 'gal* (бодтой харш, дашрамд харш)
- (14) *khyab mnyam* (түгэл сацуу)
- (15) *yin gyur min gyur* (мөн болох, бус болох)
- (16) *yin log min log* (мөнөөс буцах, бусаас буцах)
- (17) *yod rtogs med rtogs* (буй хэмээн онох, үгүй хэмээн онох)
- (18) *rtag rtogs dngos rtogs* (мөнхийг онох, бодыг онох) [Лондол лам: 26]

Чава шалгадгийн хураангуйг боловсруулахдаа чойрын номонд суралцагсдыг зиндаа болгон ангилж тус тусын түвшинд нь тохируулсан шаталсан сургалтын хөтөлбөр, дамжаа барих буюу эрдмийн зэрэг хамгаалах ёс зэргийг бий болгожээ. Төвд, Монголын чойрын дацангууд¹³² Чава-гийн тогтоосон системээр сургалтаа явуулж, зэрэг хамгаалуулдаг байсан ба түүнийг зөвхөн төвдөөр тогтохгүй дэлхийн олон оронд ямар нэг байдлаар одоо ч хэрэглэсээр байгаа юм¹³³. Жишээлбэл, Их Хүрээний Дашчойнпэл¹³⁴ дацангийн зиндааны тогтолцоо дараахь байдалтай байжээ.

1. *Хадог* (kha dog - өнгө)
2. *Шидүв* (gzhi sgrub – суурь бүтсэн)
3. *Жумбрай* (rgyu 'bras – шалтгаан, үр)
4. *Юлжан* (yul can - вишайт) гэсэн *шалгадаг ухааны зиндаа* (tshad ma'i 'dzin grwa)
5. *Дондүнжү* (don bdun bcu – далан утга)
6. *Шүнсар ог* (gzhung gsar 'og – шинэ шүнгийн доод)
7. *Шүнсар гон* (gzhung gsar gong – шинэ шүнгийн дээд)
8. *Гав данбо* (skabs dang po – анхан үес)
9. *Дом* (sdom – товч) гэсэн *билиг барамидын зиндаа* (phar phyin 'dzin grwa)
10. *Ум сарва* (dbu ma gsar ba – мадхьямакын шинэ)

¹³² Томоохон хүрээ, хийдүүдийн дэргэдэх философи, логикийн сургуулийг чойрын дацан буюу цанид дацан гэнэ.

¹³³ Энэ талаар William Magee, "Three Models of Teaching Collected Topics Outside of Tibet" /www.mtac.gov.tw/-ээс дэлгэрүүлэн үзнэ үү.

¹³⁴ Монголын анхны чойрын дацан бөгөөд 1756 онд Их Хүрээнд байгуулагджээ. Энэ дацангаас монголын нэрт гүн ухаантнууд болох Агваанбалдан, Шижээ, Лувсандаш, Шагдар нар төрөн гарсан ба XX зууны эхэн үед 5000-6000 орчим ламтай байжээ.

11. Ум нинва (dbu ma rnying ba – мадхьямакын хуучин) гэсэн *мадхьямакын зиндаа* (dbu ma'i 'dzin grwa)
12. Зод (mdzod – илт ном)
13. Гаарамба ог (bka' rams pa 'og – зарлиг машид хэтэрсний доод)
14. Гаарамба (bka' rams pa – зарлиг машид хэтэрсэн) гэсэн *абхидхарма, винайн зиндаа* (mdzod 'dul 'dzin grwa) нийт тус бүрд нь нэг жил суралцах 14 зиндаатай байжээ¹³⁵.

Үүнээс шалгадаг ухааны дөрвөн зиндаа, билиг барамидын таван зиндааг дүүргэж *гэвшийн* дамжаа барьдаг, улмаар мадхьямакийн хоёр зиндаа, абхидхарма, винайн гурван зиндааг дүүргэж *гавжад тушаагдах* буюу гавжийн дамжаа барих эрхтэй болдог байжээ. Харин хэзээ гавж болох хугацаа нь заавал тодорхой байх албагүй, 5-10 жилийн дараа ч хамгаалсан болдог ба энэ хугацаанд чойрын таван боть тус бүрээр нь эх сурвалж бүтээлүүдийг нарийвчлан судалж, онолын бэлтгэл хийдэг байсан байна. Шалгадаг ухааны зиндаанд анхлан орсноос эхлэн гавж болох хүртэл ойролцоогоор 20 орчим жил шаардагддаг байжээ¹³⁶. Гавжаас гадна *лхарамба, дооромбо, равжсамба* зэргүүдийг төвдийн дацангууд олгодог байсан ба эдгээр нь чойрын сургалтын хөтөлбөрийг бүрэн дүүргэснийг илэрхийлсэн мяндаг юм.

Чава-гийн хийсэн дараагийн нэг чухал зүйл нь шалгадаг ухааны сэдвүүдийг хэлцэх асуулт хариулт (thal phyir)-ын арга болон дагсал хаялцах (мэтгэлцэх) дэг ёсыг тогтоосон явдал юм. Чава гарамгай шалгадаг ухаантан байгаад зогсохгүй нэрт хэл зүйч байсан ба тухайн үедээ *төвд хэлийг өгүүлэхүйеэ нэн мэргэн* хэмээн алдаршиж байжээ [Хайви-гаадон: 729]. Тиймээс тэрээр юуны түрүүнд төвд хэлний онцлогт тохирсон өвөрмөц бүтэц бүхий шалгадаг ухааны хэлийг боловсруулсан буюу өөрөөр хэлбэл буддын шалгадаг ухааны төвд хэлт категорын аппаратыг боловсруулан цэгцэлсэн байдаг. Үүн дээрээ үндэслэн асуулт асуух, хариулт хариулах дэг ёс, асуугч этгээд нь зиндааны голд босч зогсон дамжаа баригч (хариулагч) этгээдэд хүндэтгэл үзүүлсний дараа асуултаа асуух, асуулт асуухдаа алга таших, илтэд буруу хариулсан бол *хорсомдох* буюу дийлдэх нь лавтай болсоныг илтгэж сүрийг үзүүлэх, маргааныг таслах зэрэг төвд хэлээр ном хэлэлцэх тогтсон дэгийг бий болгож, хөгжүүлсэн ажээ.

Эдгээрийн үндсэн дээр Чава Чойжисэнгээг дүйра-г үндэслэгч хэмээн албан ёсоор тооцдог бөгөөд дүйра бий болсноор төвд хэлт буддын шалгадаг ухаан жинхэнэ утгаараа бий болсон гэж үздэг.

Дүйра зохиолууд

Төвд, Монголын буддын мэргэд дүйра ном зохиол (bsdus gzhung)-ын арвин баялаг өв санг бүрдүүлжээ. Дүйра зохиолууд гэдэгт дүйра-ны үндсэн болон нэмэлт, туслах зохиолуудыг хамруулан ойлгож болно. Үүнээс *дүйра-ны үндсэн зохиолуудад* томоохон хэмжээний буюу бүрэн гүйцэд (cha tshang ba), дунд зэргийн ('bring po), товчхон (mdor bsdus), ерөнхий утгыг гаргасан (spyi don), хураангуй утгыг гаргасан (bsdus don), шүлэглэсэн (rtsa tshig), хэсэгчилсэн (tho re bar bkod pa, thor bu), нэгэн зүйл дагнасан (bsdus tshan rkyang pa), магадлан шинжилсэн (mtha' dpyod) зохиолуудыг, *дүйра-ны нэмэлт зохиолуудад* мэтгэлцээний сэдэв дагнасан (rtags gsal rkyang pa), үндсэн үзэл баримтлал дагнасан (rang lugs rkyang pa), туурвилаас цацарсан (rtsom 'phro), аль нэгэн дүйра зохиолын үг, утгыг тайлбарласан (tshig don 'grel pa), ишлэлийг

¹³⁵ Гандантэгчэнлин хийдийн Дашчойнпэл дацан одоо ч гэсэн зиндааны энэ тогтолцоогоор сургалтаа явуулж, гэвшийн болон гавжийн дамжаа бариулдаг уламжлалаа хадгалсаар буй.

¹³⁶ Их Хүрээний чойрын дацангийн уламжлалт сургалтын талаар “Буддын онолын сургалтын уламжлал” (Г.Лувсанцэрэн, Буддын гүн ухааны онол, түүхийн асуудлаас, УБ., 2008, 245-252 дахь тал) илтгэлээс дэлгэрүүлэн үзнэ үү.

тайлбарласан ('bru 'grel, zug mchan), сэжгийг тасалсан (dogs gcod) зохиолуудыг, *дүйра-ны туслах зохиолуудад* мэдэгдэхүүнийг зүйлчилсэн (shes bya'i rnam grangs), ухагдахууныг зүйлчилсэн (ming gi rnam grangs), асуулт, хариулт (dris lan), тэмдэглэл (brjed tho) зохиолуудыг хамруулан ойлгож болно.

Дүйра зохиолуудыг уламжлал хийгээд үзэл баримтлалынх нь үүднээс *радод уламжлалын* болон *бусад уламжлалын* хэмээн үндсэн хоёр хэсэгт ангилж болохоор байна. Үүний радод уламжлалын дүйраг *үндсэн шүнгийн дүйра* (gzhung phyi mo'i bsdus grwa), *зүг барьсан дүйра* (phyogs 'dzin pa'i bsdus grwa) хэмээн хоёр, зүг барьсан дүйраг *гүнчэн игча* (kun mkhyen yig cha)-ны, *бусад игча* (yig cha gzhan)-ны хэмээн тус тус ангилж болох юм. Үндсэн шүнгийн дүйра гэдэгт аль нэгэн чиглэлд үл хамаарах бөгөөд Радод дацангийн үндсэн уламжлалын дагуу бичигдсэн нилээд эхэн үеийн *шалгадгийн хураангуй* болон дүйра зохиолууд болох Чава Чойжисэнгийн "Шалгадгийн хураангуй", Жамъян Чоглха-Одсэрийн "Раат дүйра", Агваанпрэнлэйлхүндүвийн "Риглам дүйра" зэргийг, гүнчэн игча-ны дүйранд Гүнчэн Жамъяншадавын "Дүйра зациг" болон түүний үзэл баримтлалын дагуу бичсэн Агваандашийн "Сэ дүйра", Ханчэн Гэндэнжамцын "Лүнриг нима", Лувсандашын "Онцар гаадон" зэргийг, бусад игча-ны дүйранд Шантипа Лодойжанцангийн арван дэвтэр бүхий Дашлхүнбийн игча-ны дүйра, Цахар гэвш Лувсанчүлтэмийн сэрийн игча-ны дагуу бичигдсэн найман дэвтэр дүйра, Зава Дамдингийн банчэн игча-ны дагуу бичигдсэн "Дүйра зациг" зэргийг, бусад уламжлалын дүйранд Жонан Лодойдагвын "Ринчэн донмэ" хэмээх жонан ёсны дүйра, Саж Чойнамжалын дүйра, Данбаравжаагийн гаржүдвийн ёсны дүйра¹³⁷ зэргийг жишээ болгон дурдаж болно.

Бидэнд одоогоор дүйра-ны агуулгыг харьцангуй бүрэн хамарсан 30 орчим, нэгэн сэдвийг дагнасан олон тооны дүйра зохиол мэдэгдээд байна.

Радод дацангийн ширээт лам Жамъян Чоглха-Одсэр (1429-1500)-ийн сургаалыг тэмдэглэсэн хэмээх "Шалгадаг тийн тайлбарын хураангуй шүн, мэдэгдэхүүний үүдийг нээгч, эсэргүүлэх муу зааныг дарах арслангийн их инээд, учир шалтгааны ухааны түлхүүр" нэртэй зохиол байдаг нь одоогоор хамгийн анхны дүйра хэмээн тооцогддог. Энэ зохиол нь төвдөд "Дагцан дүйра" (stag tshang bsdus grwa), монголд "Раат дүйра"¹³⁸ нэрээрээ алдартай. Тус дүйра-нд Чавагийн үеэс уламжлан ирсэн дүйра-ны 18 сэдвийг 21 болгон өргөжүүлж, сэдэв тус бүрийг "Тийн тайлбар"-ийн ямар шүнгээс улбаалан хэлэлцэгдэх болсныг заасан¹³⁹, мөн тухайн сэдэв бүрийг *гаг-шаг-бонсүмийн*¹⁴⁰ арга буюу эсрэг үзлийг няцаах, өөрийн үзлийг илэрхийлэх, түүнтэй холбогдуулан үүсэх маргааныг шийдвэрлэх гэсэн гурвалсан арга зүйн үүднээс авч үзсэн байдаг. *Раат дүйра* нь Чавагийн уламжлалд голлон тулгуурласан боловч *Rigs gter*¹⁴¹-ийн зарим байр суурийг дэмжсэн бөгөөд [Onada: 7] зөвхөн гэлүгвийнхээр тогтохгүй сажийн хийдүүдэд ч дүйра-нд суралцах гол игча болон хэрэглэгдэж иржээ. *Раат* нь анхны дүйра зохиол гэдэг

¹³⁷ Эдгээр дүйра зохиолуудын төвд, монгол бүтэн нэрийг хавсралтаас үзнэ үү.

¹³⁸ Ra stod bsdus grwa - үндсэн дуудлага нь *Радод дүйра* бөгөөд монголчууд *Раат дүйра* хэмээн дуудна.

¹³⁹ bsdus tshan rnam kyi 'phros gzhung bkod pa

¹⁴⁰ dgag bzhag spong gsum /хаах, талбих, тэвчих гурав/ буюу kha cig dgag pa, rang lugs bzhag pa, rtsod pa spong ba gsum – заримуудыг хаах, өөрийн ёсонг талбих, тэмцлийг тэвчих гурав

¹⁴¹ Саж пантида Гунгаажанцангийн зохиосон *Rigs gter* буюу "Зохист ухааны сан" - *шалгадгийн хураангуйн* эхэн үеийн зохиол. Тус зохиолын үзэл санаа нь Төвд, Монголд дэлгэрсэн буддын шалгадаг ухааны хөгжилд үлэмж нөлөө үзүүлжээ.

утгаараа буддын шалгадаг ухааны чиглэлээр *дүйра* хэмээх зохиол бичлэгийн шинэ төрлийг бий болгосноос гадна түүний *дүйра*-ны сэдвийн ерөнхий болон дэд ангилалууд, арга зүйн хандлага зэрэг нь хожмын *дүйра* зохиолуудад уламжлагдсан юм.

Төвдийн донхор хутагт Жамбалгэндэнжамц (XVIII зуун), Их хүрээний аграмба, хувилгааны лам Лувсанчойнзин (XIX-XX зуун), Мөрөнгийн хүрээний аграмба Цэрэнжав (XIX-XX зуун), Их хүрээний гавж Зава Дамдин (1867-1937) нар “Раат *дүйра*”-нд нэмэлт тайлбаруудыг¹⁴² зохиосон байдаг.

Дүйра-ны хөгжилд ихээхэн нөлөө үзүүлсэн өөр нэгэн зохиол бол Занбо хийдийн ханбо Агваанпринлайлхүндүв (1622-1699)-ийн туурвисан “*Дүйра*-ны бүрэн агуулга, зохист ухааны орныг сайтар номлосон хүү сан” зохиол юм. Тэрээр энэ зохиолоо Радод дацангийн XIV ширээт лам Дамчойнамжал (XVII зуун)-ын сургаал дээр үндэслэн¹⁴³ бичсэн гэдэг [Лүнриг-нима: 8a]. Төвдөд “Занбо *дүйра*” (btsan po), монголд “Риглам *дүйра*” (rigs lam) нэрээрээ алдартай тус *дүйра* нь шалгадаг ухааны сургалттай гэлүгвийн дацангуудад *дүйра*-нд суралцах анхан шатны сурах бичиг (yig cha) болон хэрэглэгдэж иржээ. *Риглам дүйра* нь Гүнчэн ламын *дүйра*-ны уламжлалд ихээхэн нөлөө үзүүлсэн байдаг.

Дүйра зацигуудын дотроос Гүнчэн Жамъяншадавын анхдугаар дүр Агваанзондуйн (1648-1721) “Хураангуй найруулгын шим бүхнийг хураасан ухааны сан” хэмээх томоохон бүтээлийг давын өмнө дурдваас зохино. Урьд зургадугаар далай лам Цанъянжамц (1683-1706?) мэдлэг ухаанд суралцаж байх үест Дэсрид Санжайжамц (1652-1705) бээр Радод ширээт Цүлтимринчэн тэргүүтэн лам нараас *дүйра*-ны сэдвүүдийн тоог лавласанд зөрүүтэй хариултууд олон гарсан тул Гүнчэн ламаас магадлан асуужээ. Түүний хариу болгож Гүнчэн лам *дүйра*-ны гол анисийг нягтад хураангуйлан шүлэглэсэн “*Дүйжор зава*”-г туурвисан байдаг. Тэрээр зохиолынхоо эхэнд:

«Номт ялгалын суурийг номлох хийгээд

Номын ялгаварыг номлох ба

Магадлагдахууны тийн агуулга хийгээд

Магадлагч хэтрүүлэхүйг номлох ба

Үзэл мадхьямакад орох ёсон

*Тавуул энэ үесийн хураангуй утга мөн»*¹⁴⁴ [*Дүйжор зава*: 1б]

хэмээн *дүйра*-ны гол агуулгыг таван зүйлд хураангуйлан томъёолжээ. Үүний нэгдүгээрт, *номт-ялгалын суурь* буюу ахуйн суурь ойлголтууд болох мэдэгдэхүүн (shes bya), үлигдэхүүн (gzhal bya), ном (chos), вишай (yul), шүтэн барилдлага (rten 'brel) зэрэг ерөнхий ойлголтуудыг ижил түвшинд авч үзсэн байна. Хоёрдугаарт, *номын ялгавар* буюу дээрхи суурь ойлголтуудын задаргааг “бод” (dngos po) хийгээд “мөнх” (rtag pa), “бэлгэ чанар” (mtshan nyid) хийгээд “бэлгэдэгдэхүүн” (mtshon bya), “хуран үүдсэн” ('dus byas) хийгээд “хуран эс үүдсэн” ('dus ma byas) улмаар “өлөг” (bem po), “мэдэл” (shes pa), “төгөлдөр бус хуран үүдсэн” (ldan min 'du byed), “цогц” (phung po), “язгуур” (khams), “төрөн түгэхүй” (skye mched) зэрэг ойлголтуудаар дэлгэрүүлэн талбарлажээ. Гуравдугаарт, *магадлагдахууны тийн агуулга* буюу *дүйра*-ны судлагдахууны агуулгыг “харш, барилдлага” ('gal 'brel), “ерөнхий, тусгай” (spyi bye brag), “шалтгаан, үр” (rgyu 'bras) зэрэг арван гурван сэдвээр нарийвчлан шинжилжээ. Дөрөвдүгээрт, *магадлагч*

¹⁴² Эдгээр зохиолын талаар хавсралтаас үзнэ үү.

¹⁴³ Лондол лам *Занбо дүйра*-г Дамчойнамжил ариутган шүүсэн хэмээжээ /tshad ma nam 'grel sogs gtan tshig rig pa las byung ba'i ming gi grangs/.

¹⁴⁴ Chos can dbye gzhi bshad pa dang. Chos kyi dbye ba bstan pa dang. Nges bar bya ba'i nam bzhaq dang. Nges byed thal 'gyur bshad pa dang. lTa ba dbu mar 'jug pa'i tshul. lNga po skabs 'di'i bsdus don yin.

хэтрүүлэхүй буюу дүйра-ны сэдвүүдийг судлах үндсэн арга барил болох хэтрүүлэхүй (thal 'gyur) хэмээх гурван ёст гаргалгааны үндсэн агуулга болон буддын шалгадаг ухаан дахь маргаан, мэтгэлцээн, асуулт, хариултын зарчмуудыг задлан авч үзжээ. Эцэст нь үзэл мэдхьямакад орох ёсон буюу:

«Гадна, дотны бод бүхэн номт,
Би үгүй мөн бөлгөө, юун учир хэмээвээс,
Би үгүй бус ч [түүний] учир,
Хэмээсэн их нотлолын утга [нь]
Ном бүхэн туурвилаас хагацсан-би үгүй бөлгөө,
Би үгүй бус нь ч би үгүй болой,
Хэмээсний ахуй ёсон мэдхьямакад оршмуй.
Бас бус хураангуйн зохист ухаанд
Шинжилвээс эх, адгийг үл олох бөгөөд
Дундадад ч үл орших бөлгөө.
Аман авахуй бүхэн эвдэрмүй.
Эх, адаг үгүй бөгөөд төв үл зоригдох.
Аман авахуй үгүй бөгөөд тогтсон таалал үгүй.

Тэр цагт их мэдхьямака болой»¹⁴⁵ [Дүйжор зава: 106-11a] хэмээн дүйра-ны арга зүйн мөн чанар нь дундын зам мөрд оршдог, түүнд судлан суралцваас эцэстээ төв үзэлд хүрдэг болохыг нотлон өгүүлсэн буй.

“Дүйжор зава” зохиолд “шүтэн барилдлага”-ыг ахуйн суурь ойлголтын түвшинд авч үзсэн; цогц, язгуур, төрөн түгэхүйн асуудлыг нарийвчлан задалсан; дүйра-ны ухаан нь эцэстээ төв үзэлд хүргэдэг тухай нотолгоо хийсэн зэрэг нь дүйра бол зөвхөн нэг тогтсон тааллын хүрээнд бус буддын дөрвөн тогтсон тааллын хүрээнд асуудлыг авч үздэг болохыг, түүнчлэн шалгадаг ухаанаар тогтохгүй мэдхьямака, абхидхарма зэрэгт ч суралцах удиртгал болдгийн нэгэн жишээг үзүүлсэн хэрэг юм. Үнэхээр ч хожмын үеийн дүйра зохиолууд нь шалгадаг ухааны дүрэм, зарчмуудын хатуу хайрцган дотор буддын бусад тогтсон тааллуудын нарийн асуудлуудыг ч авч үзэх хандлагатай болсон ба энэ нь улмаар дүйра-г ерөөс буддын философийн удиртгал болохуйц түвшинд аваачсан юм. Энд ялангуяа дүйра-ны арга зүйн түгээмэл ач холбогдлыг дүйра-чид ихэд онцолж байсан болно.

“Дүйжор зава”-гаас гадна Гүнчэн ламын айлдсаныг тэмдэглэж авсан хэмээх нийт дөрвөн дэвтэр бүхий дүйра зохиол түүний сүнбүмийн *ga* ботид байдаг¹⁴⁶. Гүнчэн лам “Дүйжор зава”-г оролцуулан эдгээр зохиолууддаа дүйра-ны нийт 25 сэдвийг боловсруулжээ.

Гүнчэн ламын дээрх зохиолд Лавран хийдийн эрдэмтэн *Гүнтэн Лодой* хэмээх Лодойжамц “Хураангуй найруулгын шимийн тааллын утгыг тодруулагч тодорхой толь” нэртэй тайлбар бичсэн байдаг. Тэрээр энэхүү тайлбартаа Гүнчэн ламын дүйра-ны сургаал нь ямар ямар эх сурвалжуудаас улбаалсан болохыг тодруулан зааснаас гадна тодорхой асуудлуудын талаархи түүний үндэслэлүүдийг нотлох оролдлого хийснээрээ

¹⁴⁵ Phyi nang dngos po kun chos can. bDag med yin te ci'i phyir na. bDag med ma yin pa yi phyir. Zhes pa'i gtan tshigs chen po'i don. Chos kun spros bral bdag med de. bDag med min pa'ng bdag med do. Zhes pa'i gnas tshul dbu mar zhugs. gZhan yang bsdu pa'i rigs pa la. dPyad na thog mtha' mi rnyed cing. dBus su'ng gnas par mi 'gyur te. Khas blangs thams cad 'jig par 'gyur. Thog mtha' med cing dbus mi dmigs. Khas blangs med cing grub mtha' med. De'i tshe dbu ma chen po'o.

¹⁴⁶ Энэ талаар хавсралтаас үзнэ үү.

онцлог юм. Мөн тэрээр Гүнчэн игчаны дүйра-ны үзэл баримтлалуудад нарийн *шивча*¹⁴⁷ хийсэн нь онцгой ач холбогдолтой болсон буй.

Дүйра-ны сэдвүүдийг тус бүрээр нь нухацтай авч үзэх Гүнчэн ламын игча-г түүний шавь нар уламжлан хөгжүүлж томоохон хэмжээний дүйра зохиолуудыг туурвисан байдаг. Тухайлбал, Гүнчэн ламын шавь Сэ Агваандаш (1678-1738) “Шалгадгийн тааллыг тайлсан их шастар *Тийн тайлбарын* утгыг нэгэн дор эвхэж, оюун машид, дунд, адаг гуравт үзүүлсэн их сайн номлол, мэргэдийн хүзүүний чимэг, сайн хувьтын эгээрэл бүхнийг хангагч” хэмээх 26 сэдэв бүхий дүйра зохиолыг бичсэн нь “Сэ дүйра” хэмээн алдаршиж гүнчэн игча-ны дацангуудад дүйра-нд суралцах гол сурах бичиг болон хэрэглэгдэж иржээ. “Сэ дүйра” нь дүйра-нд хандах Гүнчэн ламын хандлагыг нарийвчлан тодотгож тогтсон хэв загварт оруулан бичсэн анхны дүйра гэдгээрээ онцлог болно. Түүнчлэн Агваандашын хөтөлсөн дүйра-ны хөтөлбөрүүдийн адил бус 30 орчим тэмдэглэл (*zin bris*) бий [GKRN: 414] гэсэн мэдээ байдаг ба тэдгээрээс зарим нь түүний “Арван гурван тэмдэглэл”¹⁴⁸ хэмээх эмхтгэлд хэвлэгджээ.

“Сэ дүйра”-нд Лавран хийдийн дооромбо Баарий Лувсанравсал (1840-1912) “Дүйра-ны үндсэн үгс, гэгээн тунгалаг толь” нэртэй нэгэн *зациг* зохиолыг бичсэн буй.

Гүнчэн ламын шавь Ханчэн /их хамба/ Гэндэнжамц (1679-1765) “Дүйра-ны сайн номлол тоолшгүй сайн хувьтын оюуны лянхуан цэцэрлэг мөшөөх эш онолын наран” хэмээх томоохон хэмжээний дүйра зохиол бичсэн нь дүйрачдын дунд “Лүнриг нима” гэдэг нэрээрээ алдартай. Гэндэнжамц энэ зохиолдоо Гүнчэн ламын дүйра-ны сэдвүүдийг лавшруулан задалж “асуухуй, орхихуй” (*dris 'phangs*), “учирын найруулга” (*rtags sbyor*), “бэлгэдлийн найруулга” (*mtshon sbyor*) зэргийг Радодын уламжлалаас авч, “хутагтын дөрвөн үнэн” (*'phags pa'i bden pa bzhi*) сэдвийг нэмсэнээр дүйра-ны хамгийн олон буюу нийт 30 сэдвийг боловсруулсан байна. “Лүнриг нима”-гийн нэг гол онцлог бол “өнгөний агуулга” (*kha dog gi rnam bzhas*) сэдвийг дээд, доод абхидхармын ёсны цогц, язгуур, төрөн түгэхүйн асуудлаар баяжуулан, ойлголт тус бүрт холбогдох олон талт маргаан мэтгэлцээний сэжүүрүүдийг гаргаж, бусад сэдвүүдтэй нь харьцуулахад нилээд нухацтай авч үзсэн явдал юм. Тэрээр энэ сэдвийг дэлгэрүүлэн авч үзэхийн үндэслэл нь нэгдүгээрт: дүйра бол зөвхөн шалгадаг ухааны бус, ерөөс таван ухааны утгыг ойлгох түлхүүр учраас абхидхармын ёсонд дэлгэрүүлэн хэлэлцдэг эдгээр ойлголтуудын агуулгыг мэдэх нь абхидхарма-д суралцахад дөхөм болно. Хоёрдугаарт: Чандракирти бээр мадхьямакын ёсон лугаа зохилдонгуйгаар “Таван цогцын бөлөг” (*phung po lnga'i rab tu byed pa*) хэмээх шастарыг туурвисны өмнөтгөлд *оюуныг эс судалсан нугуудын оюуны амыг нээхийн учир цогц, төрөн түгэхүй, язгуур нугуудын товчлон хураасан үнэхээр бэлгэ чанарыг өгүүлмүй*¹⁴⁹ хэмээсний адилаар судар, шастарын утганд суралцаагүй шинэхэн оюунтаны оюуны амыг нээхийн тулд цогц, язгуур, төрөн түгэхүйн бэлгэ чанарыг дэлгэрүүлэн авч үзэх хэрэгтэй хэмээн тайлбарлажээ [Лүнриг-нима: 49a-51a]. “Лүнриг нима” нь дүйра-ны сэдвүүдийг бүрэн хэмжээгээр, хамгийн системтэй авч үзсэн зохиолд зүй ёсоор тооцогддог.

Дүйра-ны сэдвүүдийг системтэй авч үзсэн өөр нэг чухал эх сурвалж бол дүйрачдын дунд “Нима одсэр” нэрээрээ алдартай “Зохист ухааны үүдийг нээгч хураангуй шүн, сайн номлол нарны гэгээн гэрэл” зохиол юм. Тус зохиолыг Лавран хийдийн ширээт лам, равжамба Ра Содномванжал өөрийн багш Гүнчэн ламын 2-р дүр Гончогжигмэдвамбын *Гүнчэн лам эцэг хөвгүүний хураангуй шүн хэсэг бусаг байгаа*

¹⁴⁷ *zhib cha* - хоорондоо зөрүүтэй мэт үзэл баримтлалуудын үл зөрөх нарийн ялгааг нягтлан гаргахыг *шивча хийх* хэмээнэ.

¹⁴⁸ Сэ Агваандаш, *Zin bris bcu gsum*. Лавран хийдийн бар

¹⁴⁹ *bLo gros sbyangs pa med rnam kyī. bLo yi kha ni dbye ba'i phyir. Phung po skyē mched kham s rnam kyī. mDor bsdus yang dag mtshan nyid brjod.*

нуугуудын утгыг нэгэн зүгт хураангуйлан сайн номлолоор чимсэн ойлгохуйяа хялбар нэгнийг зохио¹⁵⁰ [Нима-одсэр: 175а] хэмээсэн хүсэлтийн дагуу бичсэн байдаг. Содномванжалын дүйра нь дүйра-ны сэдэв тус бүрийн ойлголтуудаас гадна дүйранд хэрэглэгддэг буддын шалгадаг ухааны ерөнхий олголтуудыг эх сурвалжууд дээр үндэслэн ойлгомжтой, энгийн байдлаар тайлбарласнаараа онцлог юм.

Гончоогжигмэдвамбын алдартай шавь нарын дотороос *Гунтан гэгээн* хэмээн алдаршсан Гончогданбийдонмэ (1762-1823) “Зохист ухааны мөр, оньсон түлхүүр” (1795) хэмээх 11 хуудас бүхий, хэдийгээр хэмжээний хувьд жижиг боловч ихээхэн ач холбогдол бүхий зохиолыг туурвисан байдаг. Энэ дүйра-ны талаар Балман Гончоогжанцан «дүйра-ны олон сэдвээс зохист ухааныг хураангуйлсан хөтөлбөрийг айлдсанд дүйрачид тэмдэглэн авч мэлмийд нь толилуулсанд төгсгөлд нь зарим нэгэн шүлэг хайрласан»¹⁵¹ [Лавран данрав: 476] гэж тэмдэглэсэн буй. Тус зохиолд дүйра-ны сэдвүүдийг нэг бүрчлэн авч үзээгүй, харин нэгэнт ойлгомжтой мэт олон тааллуудыг задалж дүйра-ны аливаа асуудлуудыг нэг мөр болгон ойлгоход бэрхшээлтэй болохыг илтгэсэн нь нэг талаар Гүнчэн ламын дэвшүүлсэн “дүйра-ны арга зүйн мөн чанар нь дундын зам мөрд оршдог” тухай үндэслэлийг нотолсон хэрэг, нөгөө талаар дүйра бол мөнхийг мөн, бишийг биш хэмээн нотлохыг зорьдог бус, харин ч “мөнхийг биш, бишийг мөн хэмээн нотолж чадах бөгөөс дүйра-нд мэргэжсэний шинж”¹⁵² [Онцар-гаадон: 37а, Дүйра зациг: 46] хэмээх эртний нэгэн үгийн илэрхийлэл болсон хэрэг ажгуу.

Орчин цагийн Лавран хийдийн шалгадаг ухааны сургалтын түвшинг илтгэхүйц нэгэн дүйра зохиолыг Лавран хийдийн дооромбо Жамъянжинбажамц 1964 онд бичсэн байдаг. “Дүйра-ны тийн агуулга зохист ухааны галбарваасын цэцэг” нэртэй тус зохиолд дүйра-ны 25 сэдэв тус бүрт холбогдох нарийн нягтлалуудыг хийсэн буй.

Дүйра-ны хөгжилд монголын эрдэмтэн лам нар үлэмж хувь нэмэр оруулсан юм. Их хүрээний гавж Лувсандаш (XIX зуун) нийт 10 орчим сэдвийг авч үзсэн найман дэвтэр бүхий дүйра (нэмэлтийн хамтаар) зохиосон нь *Лувсандашийн дүйра* хэмээн ихэд алдаршиж тухайн үедээ дүйра-ны арга ухаан Монгол газар хэрхэн хөгжиж байсны илэрхийлэл болж байжээ. “Лувсандашийн дүйра”-нд дүйра-ны сэдвүүдийг бүхэлд нь авч үзэлгүй “цогц, язгуур, төрөн түгэхүй”, “суурь бүтсэн” (gzhi grub)-ий сэдвийг удиртгал болгож, “шалтгаан, үр” (rgyu 'bras), “харш, барилдлага” ('gal 'brel), “бэлгэ чанар, бэлгэдэгдэхүүн” (mtshan mtshon), “эдийн ном, няцлагын ном” (rdzas chos ldog chos), “ер, өвөрмөц” (sryi bye brag) зэргийг үндсэн сэдэв болгож, нийт 9 сэдвийг авч үзсэн нь Гүнчэн Жамъяншадавын “Дүйжор зава”-гийн үндсэн сэдвүүдийн сонголттой арга зүйн нэгдмэл үндэстэй байж болох талтай. Монголчууд “өнгөний ялгал” (kha dog gi gnam bzhaq) сэдвийг хэлэлцэхдээ цааш нь цогц, язгуур, төрөн түгэхүйн асуудлуудаар дэлгэрүүлэн хэлэлцдэггүй байжээ. Лувсандаш гавж дүйра зохиолдоо «Урьдын дээдсүүд шинэ оюунт эхлэн суралцагсад цогц, язгуур, төрөн түгэхүйн ялгаварыг дэлгэрэнгүй номлосон буй боловч бидний зах хязгаарын улсуудад дэлгэрэнгүй бөгөөс дэлгэрэнгүйн гэм буй, хураангуй бөгөөс хураангуйн гэм буй тул би дэлгэр, хураангуйн хэрт тааруулан бичсэн мөн»¹⁵³ [Онцар-гаадон: 166] хэмээн бичээд цогц, язгуур, төрөн түгэхүйн асуудлыг

¹⁵⁰ Kun mkhyen bla ma yab sras kyi bsduḡ gzhung thor bur gnas pa mams kyi don phyogs gcig tu bsduḡ te legs bshad kyis brgyan pa go bde ba 'di lta bu zhig gyis

¹⁵¹ Bsduḡ tshan mang po nas rigs bsduḡ kyi brtsi bzhaq thugs thog nas gnang ba bsduḡ grwa ba mams kyis zin bris su btab ste spyen 'bebs zhus par mjug tu tshigs bcad 'ga' zhig gnang

¹⁵² *Ваалан* дүйра-нд энэ үгийг эртний Радод дацангийн гүн ухаантнуудын үг хэмээжээ [Багсам-мэдог: 372].

¹⁵³ sNgon byon dam pa mams kyis kyang blo gsar las dang po ba mams l phung khams skyem mched kyi nam bzhaq rgyas bar bshad mod kyang rang cag mtha' 'khob kyi yul nam su rgyas na rgyas pa'i skyon yod bsduḡ na bsduḡ pa'i skyon yod bas bdag ni rgyas bsduḡ 'tsham pa bris pa yin

нилээд товч байдлаар авч үзсэний эцэст «Манай хязгаарын улсуудад шинэ оюунт эхлэн суралцагсдад өнгөний ялгаварыг дэлгэрэнгүй номлох уламжлал дэлгэрээгүй тул ийм уламжлал дэлгэрвээс болохгүй юу билээ хэмээн хүсэх сэтгэлээр хөтлөн сануулж бичсэн болой»¹⁵⁴ хэмээн өгүүлсэн байдаг. Хэрэв Лувсандаш гавжийн зохиолд дүйра-ны уламжлалд харьцангуй хожуу нэмэгдсэн “цогц, язгуур, төрөн түгэхүй”-н сэдвийг монголчууд дэлгэрэнгүй хэлэлцдэггүй байсны шалтгааныг монгол нь бурханы шашин төвлөрөн хөгжиж байсан төвдийг бодвол зах хязгаарын нутаг тул тийм уламжлал хараахан дэлгэрч амжаагүй гэсэн санаа байгаа бол нөгөө талаар монгол сэтгэгчид хожмын үеийн төвд лам нарын дүйра зохиолуудыг төдийлөн итгэмжлэн барьдаггүй, дүйра-ны ёс анх гарсан Санпү хийдийн Радод дацангийн уламжлалт “Раат дүйра”-г эш, онолын хувьд магадлан баримталдаг байсантай холбоотой юм.

Монголын алдарт гүн ухаантан Зава Дамдин (1867-1937) *Раат дүйра*-ны хураангуй болгож, “Ер эрхэм зарлигийн утгын тайлбар, зохист ухааны гол номын далайн орох олом, дүйра-ны үндсэн үгс, шинжлэгчийн зүрхний эрдэнэ” нэртэй нэгэн дүйра зацгийг бичсэн байдаг. Тэрээр энэ зохиолоо Банчэн игча-ны дагуу бичжээ¹⁵⁵. Зава лам «Шалгадгийн оньсын хураангуй чуулсан нь *дүйра* хэмээн бүрэнээ алдаршсан. Шинжлэх оюун шинэ, дунд, машид болсны ялдараа зохист ухааны бага, дунд, их мөрийг үзүүлсэн. Анханд: өнгө, суурь бүтсэн ба няцахуйг танин барихуй, мөн, бусаас буцсан, бага шалтгаан, үр, ер, өвөрмөц, эд, няцлага сэлт лүгээ долоон хураангуй бөлөг бөлгөө [Дүйра зациг: 1]... Дунд зохист ухааны агуулганд харш, барилдлага, буй онохуй, үгүй онохуй хийгээд бэлгэ, бэлгэдэгдэхүүн, их шалтгаан үр ба найман зүйл түгэхүй лүгээ таван хураангуй бөлөг [Дүйра зациг: 9a]... Дээд зохист ухааны мөрийн агуулганд зургаан дуу, хаах суурь, асуух ба орхих, хэтрүүлэхүй, бусдыг арилгах, арилган ба бүтээн орохуй, вишай хийгээд вишайт, бэлгэдлийн барилдлага, учирын барилдлага сэлт есөн хураангуй бөлөг. Нийлбэр тоо хорин нэгэн хураангуй бөлөг буюу дашрамд үүдсэн мөн болохуй, бус болохуй хийгээд завсарын хальс, хааж батлах, бүтээж балтах ба аман авахуйд одох ёсон дөрвийг нэмсэнээр хорин таван хураангуй бөлөг дор ч алдаршсан»¹⁵⁶ [Дүйра зациг: 146-15a] хэмээн *Раатын* уламжлалыг баримтлан гурван бүлэг, үндсэн хорин нэг, нэмэлт дөрвөн сэдвийн дагуу зохиолынхоо бүтэц, агуулгыг тодорхойлсон байна. “Дүйра зациг” нь эхлэн суралцагсдад шууд зориулагдаагүй, харин дүйра-ны тухайн нэгэн сэдэвт суралцсаны дараа түүний талаархи өөрийн мэдлэгээ багцалж авахад зориулагдсан шинжтэй юм. Өөрөөр хэлбэл, тухайн сэдвийн хүрээнд чухам юуг мэдэж авах ёстой вэ гэдгийг хураангуйлан багцалж, энгийн, ойлгомжтой байдлаар тайлбарласан нь “Дүйра зациг”-ийн нэгэн чухал онцлог болно. Мөн тухайн сэдвийн хүрээнд авч үздэг асуудлуудын тавил, шийдлийг зөвхөн *Радод дүйра*-ны хүрээгээр хязгаарлалгүй, бусад дүйра зохиолуудын үзэл баримтлалтай чөлөөтэй харьцуулж, тэдгээрээс чухал санаануудыг бүтээлчээр тусгаж, улмаар өөрийн гэсэн онцлог шинжийг илэрхийлсэн, үүгээрээ ч монгол мэргэдийн туурвисан бие даасан, томоохон дүйра зохиолуудын тоонд зүй ёсоор тооцогддог болно. Түүнчлэн зохиолын зарим хэсэгт дүйра-ны нарийн арга ухаануудын аман уламжлал, ялангуяа их хүрээний аман

¹⁵⁴ Rang cag mtha' 'khob kyi yul nams su blo gsar las dang po pa nams la kha dog gi nram bzahag rgyas par bstan pa'i srol ma dar pas srol dar na ci ma rung snyam du smon pa'i yid kyis bskul nas bris pa lags so

¹⁵⁵ Эл “Дүйра зациг”-т түүний дотны шавь, Авгын хошууны Балдансамбуу дооромбо Гүнчэн игча-ны дагуу тайлбар бичсэнийг Зава лам эс таалсан гэдэг яриа бий.

¹⁵⁶ Tshad ma'i gnad bsduṣ tshogs pa la. bsDus grwa zhes ni yongs l grags. sByangs blo gsar 'bring rab son ngor. Rigs lam chung 'bring chen po bstan. Dang por kha dog gzhi grub dang. lDog pa ngos 'dzin yin min log. rGyu 'bras chung ngu spyi bye brag. rDzas ldog bcas te bsduṣ tshan bdun... Rigs lam 'bring gi nam bzahag la. 'Gal 'brel yod rtogs med rtogs dang. mTshan mtshon rgyu 'bras che ba dang. Khyab pa sgo brgyad bsduṣ tshan lnga... Rigs lam chen po'i nam bzahag la. Drug sgra dgag gzhi dris 'phangs dan. Thal 'gyur gzhan sel sel sgrub 'jug. Yul dang yul can mtshon sbyor dang. rTags sbyor dang bcas bsduṣ tshan dgu. sDoms grangs bsduṣ tshan nyer gcig gam. Zhar byung yin gyur min gyur dang. Bar shun dgag gshags bsgrub gshags dang. Khas blangs song tshul bzhi bsnan pas. bsDus tshan nyi shu lngar yang grags.

уламжлал гэмээр зүйлүүдийг тусгаж өгсөн нь түүний бас нэгэн чухал онцлог юм. Зава Дамдин гавж «Тэр бас, мөн дор бус хэмээн хийгээд бус дор мөн хэмээн бүтээж мэдэх бөгөөс зохист ухаанд судалсны тэмдэг хэмээн мэргэд өгүүлэхийн учир шинэхэн оюунт нугууд нохой чулуу хөөцөлдөх мэт суралц [Дүйра зациг: 46]... Дүйра-ны хамаг зохист ухаан нь, шинжилвээс хязгаар, төвийг эс олох бөгөөд аман авахуй бүхэн эвдрэх тул туурвилаас хагацсан их мадхьямакад оршимуй. Түүнээ жич үнэн магад зохист ухааны шүн нь янадыг үзсэнээр бодын тэр ямагтыг нотлон буулгах гагц үүд хэмээн *Зөөлөн итгэлт*¹⁵⁷ багш бээр номлосон. Аяа, тодорхой оюунт хувь төгөлдөр нүгүүд нааш ирэгтүн, зохист ухааны мөрд суралц. Хамгийг болгоохуйн язгуурыг дэгжээн үйлд»¹⁵⁸ [Дүйра зациг: 246] гэх зэргээр дүйра-ны зохист ухаанууд дундын зам мөрт оршдог, түүнд уйгагүй шамдан суралцсанаар мөн болон бусын хэтийдлээс давж төв үзэлд хүргэдэг тухай онцлон тэмдэглэж байсан юм.

Дүйра-ны нэгэн сэдвээр төвд, монголын сэтгэгчид олон тооны зохиол бүтээлүүдийг туурвижээ. Тухайлбал, Жалцав Дармаринчэнгийн "Харш, барилдлагын тийн агуулга"¹⁵⁹, Балман Гончогжанцангийн "Сэтгэл, сэтгэлээс үүдсэний агуулга, өөрийн үндсийг тодруулагч толь"¹⁶⁰, Жонэ Дагвашадавын "Харш, барилдлага, эд, няцлага, даган одохуй, няцан түгэхүйн бүлэг"¹⁶¹, Анги Шагдарын "Их шалтгаан, үрийн тийн агуулга"¹⁶² зэрэг зохиолуудыг жишээ болгон дурдаж болно.

Ашигласан материал

1. **bLo bzang bkra shis**
[Онцар-гаадон] *Rigs lam gsal bar phyi ba'i mtha' dbyod ngo mtshar dga' ston* (Зохист ухааны мөрийг тодорхойяа ялгасан шинжлэл, гайхамшигт баяр хурим). Модон бар
2. *Bod kyi bstan bcos khag cig gi mtshan byang dri med shel dkar phreng ba.* (Төвдийн нэгэн аймаг шастаруудын нэрийн судалбар) Ed. by Grags pa. mTsho sngon: mTsho sngon mi rigs dpe skrun khang, 1985
3. **Bu ston rin chen grub**
[Бүдөн чойнжун] *Bu ston chos 'byung*. Delhi: Drepung Loseling Library Society, 1996
4. **bSod nams dbang rgyal**
[Нима-одсэр] *Rigs pa'i sgo 'byed bsdus gzhung legs bshad nyi ma'i 'od zer* (Зохист ухааны үүдийг нээгч хураангуй шүн, сайн номлол нарны гэгээн гэрэл). Гүсүмпунцоглин хийдийн бар
5. **Cha ris skal bzang thogs med**
[Ча-рий] *Rig gnas bcu'i dris lan blo gsal nyer mkho* (Арван ухааны асуулт, хариулт). Kan su'u: Kan su'u mi rigs dpe skrun khang, 1999
6. **Дигнага**

¹⁵⁷ Богд Зонхавыг хэлжээ.

¹⁵⁸ De yang yin la min par dang. Min la yin par bsgrub shes na. Rigs par byang ba'i rtags yin zhes. mKhas rnam smra phyir blo gsr rnam. Khyi kha'i rdo len tshul gyis lobs... bsDus grwa'i rigs pa thams cad ni. dPyad na mtha' dbus ma rnyed cing. Khas blangs thams cad 'jig 'gyur bas. sPros bral dbu ma chen por zhugs. De slad yang dag rigs gzhung ni. Tshu rol mthong bas dngos po yi. De nyid gtan la 'bebs pa'i sgo. gCig pur 'jam mgon bla mas gsungs. E ma blo gsal skal ldan rnam. Tshur shog rigs pa'i lam du spyongs. Kun mkhyen khams ni brtas bar byos.

¹⁵⁹ 'Gal 'brel gyi rnam bzhag

¹⁶⁰ Sems sems 'byung gi rnam bzhag rang rgyud gsal ba'i me long

¹⁶¹ 'Gal 'brel rdzas ldog rjes su 'gro ldog khyab skor

¹⁶² rGyu 'bras chen mo'i rnam bzhag

Шалгадаг хотлоос түүсэн, - Буддын онолын шастарууд, Буддизмын эх сурвалжууд I 1, эрхэлсэн Г.Лувсанцэрэн, УБ., 1999

7. **dGe 'dun rgya mtsho**
[Лүнрэг-нима] *bsDus grwa'i legs bshad grangs med skal bzang gi blo gros kyi pad tshal bzhad pa'i lung rigs kyi nyi ma* (Дүйра-ны сайн номлол тоолшгүй сайн хувьтын оюуны лянхуан цэцэрлэг мөшөөх эш онолын наран). Ершонсамданлин хийдийн бар
8. **dGe legs dpal bzang** (Хайдүв жэ)
[Дэвдүн] *Tshad ma'i bstan bcos sde bdun gyi rgyan yid kyi mun sel* (Шалгадгийн долоон аймаг шастарын чимэг сэтгэлийн харанхуйг арилгагч). Delhi: Drepung Loseling Library Society, 1996
9. **dKon mchog rgyal mtshan**
[Лавран данрав] *bLa brang bkra shis 'khyil gyi gdan rabs lha'i rnga chen* (Лавран Дашчил хийдийн орон суурин залгамжилсан үе зэргийн бичиг). Lan kru'u: Kan su'u mi rigs dpe skrun khang, 1991
10. **dPa' bo gtsug lag 'phreng ba**
[Хайви-гаадон] *Dam pa'i chos kyi 'khor lo bsgyur ba rnam kyi 'byung ba gsal par byed pa mkhas pa'i dga' ston* (Дээдийн номын чакраварди нугуудын гаралыг тодруулагч, мэргэдийн баяр хурим). STod cha. Beijing: Mi rigs dpe skrun khang, 1986
11. **'Gos lo gzhon nu dpal**
[Дэвтэр онбо] *Deb ther sngon po*. sTod cha. Si khron: Si khron mi rigs dpe skrun khang, 1984

Blue Annals. Book 6 (*The Translator Ngok Loden Sherap and the Philosophical Traditions Descending from Him*), <https://collab.its.virginia.edu>
Direct link: <https://collab.its.virginia.edu/access/wiki/site/6a0a05fe-de5e-40f7-80f2-1ccfa2ab7d8e/english%20translation%20-%20the%20blue%20annals.html> /2009.3.21/
12. **'jam dbyangs dgyes ba'i bshes gnyen** (Зава Дамдин)
[Дүйра зациг] *gSung rab spyi'i don 'grel rigs gzhung rgy mtsho'i 'jug ngogs bsDus grwa'i rtas tshig rtog ge'i snying nor* (Ер эрхэм зарлигийн утгын тайлбар, зохист ухааны гол номын далайн орох олом, дүйра-ны үндсэн үгс, шинжлэгчийн зүрхний эрдэнэ). Зава Дамдингийн сүнбүм. Са боть. 647-695 дахь тал. ҮНС
13. **Лувсанцэрэн Г.**
"Буддын онолын сургалтын уламжлал" - Буддын гүн ухааны онол, түүхийн асуудлаас, УБ., 2008, 245-252 дахь тал
14. **mGar rtse 'Jam dbyangs sbyin pa rgya mtsho dang 'Ba' lang dKon mchog chos 'phel**
[Барсам-мэдог] *mGar rtse sbyin pa'i bsDus grwa rigs lam dpag bsam me tog dang 'ba' lang bsDus grwa gnyis bzhugs so*
15. **Mi nyag mgon po**
[GKRN] *Gangs can mkhas dbang rim byon gyi rnam thar mdor bsDus* (Цастан мэргэний эрхэт дараалан өөд болсны товч намтар). Deb dang po. Beijing: Krung go'i bod kyi shes rig dpe skrun khang, 1996
16. **Ngag dbang bkra shis**
Zin bris bcu gsum (Арван гурван тэмдэглэл). Лавран хийдийн бар
17. **Ngag dbang blo bzang**
[Лондол лам] *Tshad ma rnam 'grel sogs gtan tshigs rig pa las byung ba'i ming gi grangs bzhugs so* (Шалгадаг тийн тайлбар тэргүүтэн нотлохуй ухаанаас гарсан нэрийн зүйл). kLong rdol bla ma ngag dbang blo bzang gi gsung bum. Pha. Хятад бар
18. **Ngag dbang brtson 'grus**
[Дүйжор зава] *bsDus sbyor gyi snying po kun bsDus rig pa'i mdzod* (Хураангуй найруулгын шим бүхнийг хураасан ухааны сан). Лхүндүвдэчэнлин хийдийн бар
19. **Ngag dbang brtson 'grus**
Kun mkhyen 'jam dbyangs bzhad pa'i rdo rje'i gsung 'bum. Ga po ti. Лавран хийдийн бар
20. **Onoda Shunzo**
bsDus grwa Literature. www.thlib.org
Direct link: <http://www.thlib.org/encyclopedias/literary/genres/genres-book.php#book=/studies-in-genres/b10/> /2009.3.21/
21. **Sanjit Kumar Sadhukhan**
[HBLT] *A Short History of Buddhist Logic in Tibet*.

22. **sKal bzang chos kyi rgyal mtshan (shing bza')**

[Шинса] *'Phags pa'i yul nas bod dang hor gyi yul du bstan pa dar tshul gyi rnam bzhas mdo tsam brjod pa pad dkar phreng mdzes* (Хутагтын орноос төвд хийгээд монголын оронд шашин дэлгэрсэн ёсны тийн агуулгыг товчийн төдий өгүүлэхүй). Gangs can rig brgya'i sgo 'byed lde mig. Deb bco brgyad pa. Beijing: Mi rigs dpe skrun khang, 1993

23. **Su dhi pra sha ka and Sras Ngag dbang bkra shis**

Tshad ma'i dgongs don rtsa 'grel mkhas pa'i mgul rgyan. Ed. by dMu dge bSam gtan. Beijing: Mi rigs dpe skrun khang, 2001

24. **William Magee**

Three Models of Teaching Collected Topics Outside of Tibet, www.mtac.gov.tw

Direct link: <http://www.mtac.gov.tw/pages/93/William%20Magee.pdf> /2009.3.21/

25. **Ye shes dpal 'byor**

[Багсам-жонсан] *Chos 'byung dpag bsam ljon bzang* (Ном гарсан ёс галбарваасан мод). mTsho sngon: Kan su'u mi rigs dpe skrun khang, 1992

Хавсралт

“Дүйра”-ны зохиолууд

№	Зохиолын нэр	Зохиогч	Тайлбар
1	tshad ma rnam 'grel gyi bsdus gzhung shes bya'i sgo 'byed rgol ngan glang po 'joms pa gdong lnga'i gad rgyngs rgyu rig lde mig (Шалгадаг тийн тайлбарын хураангуй шүн, мэдэгдэхүүний үүдийг нээгч, эсэргүүлэх муу зааныг дарах арслангийн их инээд, учир шалтгааны ухааны түлхүүр)	Жамъян Чоглха-Одсэр (1429-1500)	Зохиогч нь Төвдийн алдарт Санпү хийдийн Радод дацангийн ширээт лам. Тус зохиол Төвд, Монголд олон дахин барлагдсан. Үндсэн 21 (нэмэлт 4) сэдэв бүхий томоохон дүйра зохиол. <i>Раат дүйра</i> гэж нэрлэдэг
2	bsdus grwa'i rnam gzhag cha tshang ba rigs gnas legs bshad bang mdzod (Дүйра-ны тийн агуулга, бүрэн гүйцэд, зохист ухааны орныг сайтар номлосон хүү сан)	Агваанпринлайлхүнд үв (1622-1699)	Зохиогч нь Гүнчэн Жамъяншадавын багш. Брайвун хийдийн Гоман дацангийн хамба байсан. Сүүлд Занбо хийдийн хамба болсноор <i>Занбо номун хан</i> хэмээн алдаршсан. Тус дүйра нь Төвд, Монголд олон дахин барлагдсан. Жинданлингийн барын хэвлэл нь 98 хуудастай. Нийт 18 сэдвийг авч үзсэн. Дунд зэргийн дүйра. <i>Риглам дүйра</i> гэж нэрлэдэг
3	(Шантипа Лодойжанцангийн дүйра) /арван дэвтэр/ (1) rigs lam rnam bzhas (Зохист ухааны мөрийн агуулга) (2) rigs lam nor 'phreng (Зохист ухааны мөр, эрдэнийн эрих) (3) drug sgra (Зургадугаар дуу) (4) thal 'gyur chen mo'i rnam bzhas (Их прасангын агуулга) (5) bsdus grwa'i rnam bzhas skal bzang dga' bskyed (Дүйра-ны агуулга) (6) rgyu 'bras chen mo'i rnam bzhas (Их шалтгаан үрийн агуулга) (7) dgag gzhi chen mo (Их хаах суурь) (8) yul dang yul can gyi rnam bzhas (Вишай, вишайтын агуулга) (9) gzhan sel gyi rnam bzhas (Бусыг арилгахын агуулга) (10) rtsi tshul khyab sgrog rjes 'gro ldog gsum (Тоолох ёс, түгэлийг бодох, даган одохуй, няцахуй гурав)	Шантипа Лодойжанцан (1487-1567)	Зохиогч нь Төвдийн Дашлхүнбо хийдийн ширээт лам. <i>Банчэн Шантипа</i> хэмээн нэрлэдэг. Дашлхүнбийн игча-ны дүйра. Тус хийдэд бартай

4	bsdus sbyor gyi snying po kun bsdus rig pa'i mdzod (Хураангуй найруулгын шим бүхнийг хураасан ухааны сан)	Агваанзондүй (1648-1721)	Зохиогч нь <i>Гүнчэн Жамъяншадав</i> гэдэг нэрээрээ алдартай. Төвдийн Брайвун хийдийн Гоман дацангийн ширээт лам. Төвдийн Амдо нутгийн алдарт Лавран (1709) хийдийг үндэслэгч. Өөрийн бүтээлүүдээрээ "Гүнчэн игча" (Гүнчэн ламын дэг сургууль)-г бий болгосон. Дүйра зохиолуудад тус дүйранаас иш татахдаа <i>Дүйра зациг</i> , <i>Дүйжор зава</i> хэмээн товчлон нэрлэсэн байдаг. Төвд, Монголд олон дахин хэвлэгдсэн. Лхүндүвдэчэнлингийн бар нь 11 хуудастай. Шүлэглэсэн (rtsa tshig) зохиол. Энэ зохиолд Дүйра-г цогц үзэл баримтлалын түвшинд илэрхийлжээ.
5	(Гүнчэн ламын дүйра-ны тэмдэглэлүүд) /дөрвөн дэвтэр/ (1) kha dog dkar dmar (Цагаан, улаан өнгө) (2) bsdus grwa'i rnam bzhag legs par bshad pa (Дүйра-ны агуулгыг сайтар номлосон) (3) kun mkhyen 'jam dbyangs bzhad pas mdzad pa'i thal 'gyur che ba'i rnam bzhag mdor bsdus (Гүнчэн Жамъяншадав бээр зохиосон их прасангийн товч хураангуй агуулга) (4) bsdus chen gyi rnam bzhag rigs lam gser gyi sgo 'byed (Их хураангуйн агуулга, зохист ухааны мөрийн үүдийг нээгч)	Агваанзондүй (1648-1721)	Зохиогч нь "Дүйжор зава"-г зохиосон Гүнчэн лам. Энэ дөрвөн дэвтэр зохиол нь Гүнчэн ламын сүнбумын <i>ga</i> ботид буй. Лавран хийдэд бартай.
6	tshad ma'i dgongs 'grel gyi bstan bcos chen po rnam 'grel gyi don gcig tu dril ba blo rab 'bring tha ma gsum du ston pa legs bshad chen po mkhas pa'i mgul rgyan skal bzang re ba kun skong (Шалгадгийн тааллыг тайлсан их шастар <i>Тийн тайлбарын</i> утгыг нэгэн дор эвхэж, оюун машинд, дунд, адаг гуравт үзүүлсэн их сайн номлол, мэргэдийн хүзүүний чимэг, сайн хувьтын эгээрэл бүхнийг хангагч)	Агваандаш (1678-1738)	Зохиогч нь Гүнчэн ламын алдартай шавь нарын нэг. <i>Сэ (срай) Агваандаш</i> хэмээнэ. Тус зохиол нь <i>Сэ дүйра</i> гэдэг нэрээрээ алдартай бөгөөд Гүнчэн ламын дүйра-ны үзлийг нарийвчлан тодотгож тогтсон хэв загварт оруулжээ. Лавран хийдэд бартай. Мөн Бээжинд хэд хэдэн удаа хэвлэгдсэн.
7	bsdus grwa'i rtsom 'phro (Дүйра-ны туурвил цацрал)	Агваандаш (1678-1738)	Зохиогч нь "Сэ дүйра"-г зохиосон Агваандаш. Тус зохиолыг <i>Дүйра зомпро</i> гэж нэрлэдэг бөгөөд "Сэ дүйра"-ны үргэлжлэл болгон бичжээ. Лавран хийдэд бартай.
8	bsdus grwa'i legs bshad grangs med skal bzang gi blo gros kyi pad tshal bzhad pa'i lung rigs kyi nyi ma (Дүйра-ны сайн номлол тоолшгүй сайн хувьтын оюуны лянхуан цэцэрлэг мөшөөх эш онолын наран)	Гэндэнжамц (1679-1765)	Зохиогч нь Гүнчэн ламын алдартай шавь нарын нэг, Рон-бо хийдийн хамба. <i>Ханчэн /их хамба/ Гэндэнжамц</i> хэмээнэ. Тус зохиолыг 1761 онд туурвижээ. Дүйра зохиолуудад энэ дүйра-наас ишлэхдээ <i>Лүприг нима</i> хэмээн товчлон нэрлэсэн байдаг. Гүнчэн игча-ны алдартай дүйра зохиолуудын нэг бөгөөд дүйра-

			ны хамгийн олон (буюу 30) сэдвийг авч үзсэн томоохон хэмжээний зохиол. Ершонсамданлин хийдэд бартай.
9	rigs pa'i sgo 'byed bsdus gzhung legs bshad nyi ma'i 'od zer (Зохист ухааны үүдийг нээгч хураангуй шүн, сайн номлол нарны гэгээн гэрэл)	Содномванжал (1726-1793)	Зохиогч нь Лавран хийдийн 15-р ширээт лам. Равжамба. <i>Ра Содномванжал</i> хэмээнэ. Тус дүйра зохиолыг Гүнчэн игча-ны дагуу бичсэн бөгөөд <i>Ра дүйра, Нима одсэр</i> зэргээр товчлон нэрлэдэг. Дүйра-ны агуулгыг бүрэн хамарсан томоохон хэмжээний зохиол. Ганданравжайлин болон Гүсүмпунцоглин хийдэд бартай.
10	rigs lam 'phrul gyi lde mig (Зохист ухааны мөрийн оньсийг нээх түлхүүр)	Гончогданбийдонмэ (1762-1823)	Зохиогч нь Гүнчэн ламын 2-р дүр Гончогжигмэдвамбо-ын шавь. Лавран хийдийн ширээт лам. <i>Гунтан гэгээн</i> хэмээн алдаршсан. Гүнчэн игча-ны дүйра. Тус зохиолыг 1795 онд туурвисан бөгөөд дүйра-ны нарийн дагсалуудыг бичсэн багахан хэмжээний зохиол. Дэчэнлхүндүвлин хийдэд бартай.
11	bsdus sbyor shying po'i dgongs don gsal bar byed pa kun gsal me long (Хураангуй найруулгын шимийн тааллын утгыг тодруулагч тодорхой толь)	Лодойжамц (?)	Зохиогч нь <i>Гунтан Лодой</i> гэдэг нэрээрээ алдартай. Тус дүйра-г <i>Гүнсал мэлон</i> хэмээн товчлон нэрлэдэг. Энэ зохиол нь Гүнчэн ламын "Дүйжор зава"-гийн тайлбар бөгөөд Гүнчэн игча-ны дүйра зохиолуудын нарийн шивча-г хийжээ. Лхүндүвдэчэнлин хийдэд бартай.
12	bsdus tshan rnam kyi 'phros gzhung (Дүйра-ны сэдвүүдийн цацарсан шүн)	Лодойжамц (?)	Зохиогч нь "Дүйжор зава"-гийн тайлбарыг зохиосон Гунтан Лодой. Гүнчэн игча-ны дүйра. Тус зохиолд дүйра-ны бүлэг, зүйлүүдийн эх сурвалжуудыг тодотгон заажээ.
13	mkhas shing grub pa'i dbang phyug rje skal ldan rgya mtshos mdzad pa'i bsdus grwa'i rtsha tshig bzhugs so (Мэргэн бөгөөд бүтээлийн эрхт богд Галданжамц бээр зохиосон дүйра-ны зациг оршвой)	Галданжамц (1607-1677)	Зохиогч нь Төвдийн Амдо нутгийн Рон-бо хийдийн хамба. Дүйра-ны зарим сэдвүүдийг авч үзсэн багахан хэмжээний шүлэглэсэн (rtsha tshig) зохиол.
14	bsdus grwa'i rtsha tshig dwangs gsal me long (Дүйра-ны үндсэн үгс, гэгээн тунгалаг толь)	Лувсанравсал (1840-1912)	Зохиогч нь Лавран хийдийн дооромбо. <i>Баарий лам</i> хэмээнэ. Гүнчэн игча-ны дүйра зохиол. Тус дүйра-г Агваандашийн "Сэ дүйра"-ны хураангуй болгож шүлэглэн (rtsha tshig) зохиосон. Гүнбүм хийдэд бартай. Мөн "Сэ дүйра"-ны хамтаар Бээжинд хэд хэдэн удаа хэвлэгдсэн.
15	rigs lam thor bu'i rnam gzhag blo gsal ngang mo 'gug pa'i legs bshad padmo'i mtsho chen (Хэсэг бусаг зохист ухааны мөрийн ялгавар)	Гончогчойнпэл (XIX зуун)	Зохиогч нь Лавран хийдийн шалгадаг ухаантан. <i>Ваалан лам</i> хэмээнэ. Гүнчэн игча-ны дүйра. Тус зохиолыг <i>Ваалан дүйра</i> гэж товчлон нэрлэдэг. Дүйра-ны нарийн дагсалуудыг бичжээ. Лавран болон Ганданчойнхорлинд бартай.

			Мөн "Гарзэ Жинба-ийн дүйра"-ны хамт Хятадад хэвлэгдсэн.
16	bsdus grwa'i rnam bzhag rigs lam dpag bsam me tog (Дүйра-ны тийн агуулга зохист ухааны галбарваасын цэцэг)	Жамъянжинбажамц (XX зуун)	Зохиогч нь Лавран хийдийн дооромбо. <i>Гарзэ Жинба</i> хэмээнэ. Гүнчэн игча-ны дүйра. Тус зохиолыг 1964 онд бичсэн бөгөөд <i>Гарзэ Жинба-ийн дүйра</i> гэж товчлон нэрлэдэг. Дүйра-ны агуулгыг бүрэн хамарсан зохиол. "Ваалан дүйра"-ны хамт Хятадад хэвлэгдсэн.
17	rigs pa'i do shal (Ухааны сондор) !	Дхармакирти (Чойдаг)!	Зохиогчын нэр нь тодорхойгүй. Мөн зохиолын эхний хуудас олдоогүй. Төгсгөлийн үгнээс нь харахад зохиогч болон зохиолын нэр нь ийм байсан бололтой. Хятад зэс барын хэвлэл нь 102 хуудастай, өөрийн гэсэн онцлог бүхий, үүгээрээ ч нилээд сонирхол татахуйц дүйра зохиол болно. Тус зохиол нь Сажа Пантида Гунгаажанцангийн <i>Rigs gter</i> (Зохист ухааны сан) зохиолын бүтэц, агуулга, үзэл баримтлалын дагуу бичигдсэнээс харахад Сажийн ёсны дүйра бололтой.
18	chos rnam rgyal gyi bsdus grwa (Чойнамжалын дүйра)	Чойнамжал (XVII зуун)	Зохиогч нь Данаг Түвданнамжаллин хийдийн залгамжлагч. Сажийн игча-ны дүйра. Энэ зохиолын хуулбар нь Дарамсала дахь "Төвд зохиол бүтээл, архивийн сан хөмрөг"-д хадгалагдаж байгаа ба "dkar chag mthong bas yid 'phrog chos mdzod bye ba'i lde mig" (A Bibliography of <i>Sa skya pa</i> Literature, New Delhi, 1987)-д тус зохиолын тухай мэдээлжээ (Shunzo Onoda, <i>bsDus grwa</i> Literature. www.thdlib.com).
19	bsdus grwa'i spyi don rnam par nges pa chos rnam kyi mtshan nyid rab tu gsal bar byed pa rin po che'i sgron me (Дүйра-ны ер утгыг тийн магадласан, юмсын бэлгэ чанарыг машинд тодруулагч эрдэнийн зул)	Лодойдагва ()	Зохиогчыг нь <i>Жонан Лодойдагва</i> хэмээнэ. Жонан ёсны дүйра. 60 орчим хуудастай. www.jonangfoundation.org □д энэ дүйра-ны тухай мэдээлжээ.
20	bsdus grwa'i spyi don rnam par nges pa chos rnam kyi mtshan nyid rab tu gsal bar byed pa rin po che'i sgron me (Дүйра-ны ер утгыг тийн магадласан, юмсын бэлгэ чанарыг машинд тодруулагч эрдэнийн зул)	Түвдэнгэлэгжамц (1844-1904)	Зохиогчыг нь Жонан Гунгаадолчогийн хувилгаан <i>Ваада Гэлэг</i> хэмээнэ. Жонан ёсны дүйра. Тус зохиолын нэр нь Жонан Лодойдагвын дүйра-ны нэртэй адил боловч тусдаа зохиол юм. Уг эх нь судрын 489 хуудастай, шар бичгээр сийрүүлсэн бичмэл. "gangs ljongs shes rig gi nying bcud" (krung go'i bod kyi shes rig dpe skrun khang, Beijin, 1993) цувралд хэвлэгджээ (www.jonangfoundation.org)
21	bsdus rigs gsal ba'i nyin byed (Хураангуй зохист ухааныг тодруулагч наран)	Данбаравжаа (1970-)	Зохиогч нь Брүгва гаржүдвийн хийдийн хамба. Гаржүдвийн ёсны дүйра. Тус зохиолыг

			Гүнчэн Бадамгаравын үзэл баримтлалын дагуу бичсэн бөгөөд 2000 онд Бээжинд хэвлэгджээ.
22	Rwa ba stod kyi bsds grwa'i dka' gnad rnam phyogs gcig tu bkod pa gzhung bzang stong gi sgo 'byed (Радод дүйра-ны бэрх анис нугуудыг нэгэн зүгт байгуулсан, мянган сайн шүнгийн үүдийг нээгч сайн номлол алтан түлхүүр)	Жамбалгэндэнжамц (XVIII зуун)	Зохиогч нь Төвдийн Донхор хутагтын хувилгаан. Тус зохиолд "Раат дүйра"-ны нарийн дагсалуудыг дэлгэрүүлэн тайлбарлажээ. "Раат дүйра"-ны хамт 1992 онд Делид хэвлэгдсэн.
23	Tshad ma'i gzhung don 'byed pa'i bsds grwa'i rnam bzhag rigs lam 'phrul gyi lde mig (Шалгадгийн шүнгийн утгыг нээх дүйра-ны тийн агуулга, зохист ухааны мөрийн оньсийг нээх түлхүүр)	Жамбацүлтэмжамц (1825-1901)	Зохиогчыг нь Ёнзон нүржог Жамба ринбочэ хэмээнэ. Сэра игча-ны дүйра зохиол бөгөөд Ёнзон дүйра хэмээн товчлон нэрлэдэг. Дүйра-ны агуулгыг бүрэн хамарсан зохиол. Их хүрээний Идгаачойнзин дацанд бартай. Мөн Хятадад хэд хэдэн удаа хэвлэгдсэн.
24	(Цахар гэвшийн дүйра) /найман дэвтэр/ (1) khyab mtha' kha dog gzhi grub sogs (Чамтаа, өнгө, суурь бүтсэн тэргүүтэн) (2) kha dog dkar dmar gyi rigs lam gtong tshul (Цагаан, улаан өнгөний зохист ухааны мөрийг тавих ёс) (3) 'byung ba dang 'byung 'gyur sogs kyi ngos 'dzin (махбод хийгээд махбодоос үүдсэн тэргүүтнийг танин барихуй) (4) gzhi grub yin log sogs bsres pa'i khyab skor (Суурь бүтсэн, мөн буцсан тэргүүтнийг нийлүүлсэн түгэхүйн бүлэг) (5) mtshan mtshon gyi khab skor (Бэлгэ чанар, бэлгэдэгдэхүүний түгэхүйн бүлэг) (6) rgyu 'bras dang gzhan sel gyi yig chung (Шалтгаан, үр хийгээд бусыг арилгахуйн бага бичиг) (7) rdzas ldog dang 'gal 'brel tshig bkra bcas (Эд, няцлага хийгээд харш, барилдлага сэлт) (8) rjes khyab ldog khyab sogs las brtsams pa'i yi ge sogs (Даган түгэх, няцан түгэх тэргүүтнээс туурвисан бичиг зэрэг)	Лувсанчүлтэм (1740-1810)	Зохиогч нь Цахар хөвөөт цагаан хошууны харъяат. Цахар гэви хэмээн алдаршсан. Сэра игча-ны дүйра зохиол. Тус найман дэвтэрт дүйра-ны 10 орчим үндсэн сэдвийг авч үзсэнээс гадна ном хаялцах дэг ёсны талаар бичжээ. Нутгийн хийдэд бартай.
25	bsds gzhung gsung rab rgya mtsho'i 'jug ngogs (Хураангуй шүн эрхэм зарлигийн далайн орох олом)	Лувсанцэмбэл (XIX зуун)	Зохиогч нь Зүүн түмэд хошууны харъяат. Алдарт орчуулагч. Цэмбэл гүүш гэдэг нэрээрээ алдартай
26	(Лувсандашийн дүйра) /есөн дэвтэр/ (1) rigs lam gsal bar phyi ba'i mtha' dbyod ngo mtshar dga' ston (Зохист ухааны мөрийг тодорхойя ялгасан шинжлэл, гайхамшигт баяр хурим) (2) yin log min log gi mtha' dbyod ngo mtshar dga' ston (Мөнөөс буцсан, бусаас буцсаны магадлан шинжлэл гайхамшигт баяр хурим)	Лувсандаш (XIX зуун)	Зохиогч нь Сайн ноён хан аймгийн Дайчин вангийн хошууны харъяат. Их хүрээний гавж. Дуйнхорын Лувсандаш гэдэг нэрээрээ алдартай. Гүнчэн игча-ны дүйра зохиол. Тус есөн дэвтэрт дүйра-ны 10 орчим үндсэн сэдвийн нарийн дагсалуудыг бичжээ. Монголд бартай.

	(3) rgyu 'bras chung ngu'i mtha' dbyod ngo mtshar dga' ston (Бара шалтгаан, үрийн магадлан шинжлэл гайхамшигт баяр хурим) (4) mtshan mtshon gsal bar phyi ba'i mtha' dbyod ngo mtshar dga' ston (Бэлгэ чанар, бэлгэдэгдэхүүнийг тодорхойяа ялгасан магадлан шинжлэл гайхамшигт баяр хурим) (5) spyi dang bye brag gi mtha' dbyod ngo mtshar dga' ston (Ер хийгээд өвөрмөцийн магадлан шинжлэл гайхамшигт баяр хурим) (6) rdzas ldog gi mtha' dbyod mkhas mang dgongs gsal ngo mtshar dga' ston (Эд, няцлагын магадлан шинжлэл мэргэдийн тааллыг тодруулагч гайхамшигт баяр хурим) (7) 'gal 'brel gyi rnam bzhag gsal bar phyi ba'i mtha' dbyod ngo mtshar dga' ston (Харш, барилдлагын тийн тавилыг тодорхойяа ялгасан магадлан шинжлэл гайхамшигт баяр хурим) (8) khyab pa sgo brgyad rab gsal kun dga' nor bu (Найман зүйл түгэлийг машид тодруулагч хотолыг баясгагч эрдэнэ) (9) rigs lam gces nor zhes bya ba bzhugs so (Зохист ухааны мөрийн энхэр эд)		
27	rigs pa'i gsang tshig la nye bar mkho ba'i bsdus grwa'i rigs lam thor bu (Зохист ухааны нууц үгст чухал хэрэгтэй дүйра-ны зарим ухааны мөр)	Содномжамц (XIX зуун)	Зохиогч нь Сайн ноён хан аймгийн харъяат. Шунлайв. Төвдийн Лавран хийдийн дооромбо. <i>Ловон Содномжамц</i> хэмээнэ. Гүнчэн игча-ны дүйра. Тус зохиолд дүйра-ны нарийн дагсалуудыг бичжээ. Нутгийн хийдэд бартай.
28	stag tshang rwa stod bsdus grwa'i nang drangs gzhung 'ga'i 'bru 'grel blo gsar dga' bskyed (Дагцан Радод дүйра-ны дотор залсан зарим шүнгийн үгийн тайлбар шинэхэн оюунтаны баясалыг үүсгэгч)	Лувсанчойнзин (XIX-XX зуун)	Зохиогч нь Их хүрээний цорж. Аграмба. <i>Хувилгааны лам</i> гэдэг нэрээрээ алдартай. Тус зохиолд "Раат дүйра"-ны дотор иш татсан шүнгүүдийн утгыг тайлбарлажээ. Их хүрээнд бартай.
29	gsung rab spyi'i don 'grel rigs gzhung rgy mtsho'i 'jug ngogs bsdus grwa'i rtsa tshig rtog ge'i snying nor (Ер эрхэм зарлигийн утгын тайлбар, зохист ухааны гол номын далайн орох олом, дүйра-ны үндсэн үгс, шинжлэгчийн зүрхний эрдэнэ)	Лувсандамдин (1867-1937)	Зохиогч нь Түшээт хан аймгийн Дайчин бээсийн хошууны харъяат. Их хүрээний гавж. <i>Зава багш, Зава Дамдин</i> зэрэг нэрээрээ алдартай. Банчэн игча-ны дүйра. "Раат дүйра"-ны үндсэн утгыг хураангуйлан шүлэглэсэн (rtsa tshig) зохиол. Монголд бартай. Мөн Энэтхэгт хэвлэгдсэн.
30		Агваанцэвэг (XIX-XX зуун)	Зохиогч нь их хүрээний аграмба. Зохиолын нэр нь тодорхойгүй. Гүнчэн игча-ны дүйра. Дүйра-ны сэдвүүдийн гол үзэл баримтлалуудыг (rang lugs) авч үзсэн багахан хэмжээний бичмэл зохиол
31	bsdus tshan rnam kyi rigs lam tho re bar	Гонгор (XIX-XX зуун)	Зохиогч нь Говь түшээт вангийн

	bkod pa blo gsal dga' bskyed (Дүйра-ны сэдвүүдийн зохист ухааны мөрийг хэсэгчлэн байгуулсан, саруул оюуны баясалыг үүсгэгч)	зуун)	хошууны харъяат. Лавран хийдийн дооромбо. <i>Гонгор дооромбо</i> гэдэг нэрээрээ алдартай. Гүнчан игча-ны дүйра. Нийт 25 сэдэв, 78 хуудас бүхий бичмэл зохиол
32	shes bya'i rnam grangs blo gsal rigs sgo (Мэдэгдэхүүний зүйл, оюуныг тодруулагч зохист ухааны үүд)	Самданжамц (XX зуун)	Зохиогч нь XX зууны төвдийн нэрт эрдэмтэн, <i>Мүргэ Самдан</i> хэмээнэ. Тус зохиолд шалгадаг ухаанд суралцагсад давын өмнө мэдвээс зохих зүйлүүдийг дүйра-ны үндсэн сэдвүүдийн агуулгын дагуу энгийн ойлгомжтой байдлаар бичжээ. <i>Лосал ригго</i> хэмээн товчлон нэрлэдэг. Хөх нуурын хэвлэлийн хорооноос эрхлэн хэд хэдэн удаа хэвлэжээ.
33	dris lan gter gyi kha byang (Асуултын хариу, сангийн нэмэлт тэмдэг)	Самданжамц (XX зуун)	Зохиогч нь "Лосал ригго"-г зохиогч Мүргэ Самдан. Тус зохиолд <i>Үндэсний хэвлэлийн хорооноос</i> "Сэ дүйра"-г дахин хэвлэхэд зориулж Дүйра-ны 180 нэр томъёо, 29 тогтсон хэллэгийг тайлбарлажээ. "Сэ дүйра"-ны хамт Бээжинд хэвлэгдсэн.
34	Rgyu 'bras che ba drug sgra brtsi tshul dgag gzhi brtsi tshul rnam kyi brjed tho (Их шалтгаан үр, зургадугаар дууг тоолох ёс, хаах суурийг тоолох ёс нугуудын тэмдэглэл)	Цэрэнжав (XIX-XX зуун)	Зохиогч нь Сайн ноён хан аймгийн Далай гүний хошууны харъяат. Мөрөнгийн хүрээний аграмба. Тус зохиолд "Раат дүйра" -ны зарим сэдвүүдийн тайлбарлалтай холбогдох аман уламжлал, сонирхолтой мэдээ баримтуудыг тэмдэглэжээ. Мөрөнгийн хүрээнд бартай.